



ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХУРАЛ

2017 оны 01-р сарын 02-ны өдөр аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны эхний хурал хуралдлаа.

Хурлаар Улсын сайн малчин, улсын тэргүүний тариаланчид тодорхойлох тухай асуудлыг авч хэлэлцээд

Улсын сайн малчин цолоор:



Өлгий сумын Чаргат багийн малчин Цэвээний Доржсүрэн, Хяргас сумын Бугат багийн малчин

Бужгарын Баяртогтох, Тэс сумын Нуур багийн малчин Нинжийн Цогтоо, Бөхмөрөн сумын Хар-Алтан багийн малчин Чойндонгийн Батжаргал, Баруунтуруун сумын Зүүнтуруун багийн малчин Шаравын Даваадорж нарыг

Улсын тэргүүний тариаланч цолоор:

Тариалан сумын тариаланч Идэшийн Бүүвэй, Улаангом сумын тариаланч Түдэвийн Хүрэлбаатар, Улаангом сумын тариаланч Чангаагийн Батсуурь, Тариалан сумын тариаланч Төмөрдэйн Алтанхүү нарыг шагнуулахаар Хүнс хөдөө аж ахуйн яаманд уламжиллаа.

Мөн орон нутгийн өмчийн асуудлыг /актлах, балансаас балансад ишилжүүлэх тухай/ хэлэлцэн шийдвэрлэлээ.

АЙМГИЙН ИТХ-ЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ДОТООД ХЯНАЛТЫН ХОРОО ХУУЛЬ САХИУЛАХ БОЛОН ХЯНАЛТЫН БАЙГУУЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА

Аймгийн ИТХ-ын Хууль эрх зүй, дотоод хяналтын хорооны бүрэлдэхүүн аймгийн ИТХ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 2017 оны 01 сарын 03-05-ны хооронд аймгийн Шүүхийн тамгын газар, Прокурор,

Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Шүүх шийнжилгээний алба, Хилийн цэргийн 0245-р анги, Гадаадын иргэн харьяатын газрын Баруун бүс дэх газрын Увс аймаг дахь төлөөлөл, Татварын хэлтэс, Гаалийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг газруудын ажил байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажил арга хэмжээтэй танилцаж, иргэдэд хууль сурталчилах ажиллагаа, иргэдийн өргөдөл, гомдол санал хүсэлтийн шийдвэрлэлт, байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал, иргэдийн оролцоог дэмжих бодлого, аймгийн ИТХ-аас гарсан тогтоол шийдвэрийн



хэрэгжилтийн байдал зэрэгтэй танилцлаа.

Мөн дээрх байгууллагуудтай цаашид хэрхэн хамтран ажиллах талаарх санал хүсэлтийн авч 2017 онд аймгийн Хууль эрх зүй, дотоод хяналтын хорооны жилийн ажлын төлөвлөгөөнд тусган хамтран ажиллах зорилготой ажиллалаа.

МОНГОЛ УЛСЫН ШИНЭ ҮНДСЭН ХУУЛИЙГ БАТЛАЛЦСАН АХМАД БУУРЛУУДДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

Шинэ Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойг угтан аймгийн ИТХ-ын ажлын албанаас нутгийн ард түмнээ төлөөлөн Шинэ үндсэн хууль батлалцаж явсан ахмад буурлууд болох Хөдөлмөрийн баатар Б.Жанцансамбуу, П.Бямбажав, Ш.Бороодой, Р.Батсүх нарыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлээ.



АЙМГИЙН ИТХ-ЫН БАЙГАЛЬ ОРЧИН, ЭКОЛОГИЙН ТЭНЦВЭРТ БАЙДЛЫН ХОРООНООС ХЭЛЭЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Аймгийн ИТХ-ын Байгаль орчин, экологийн тэнцвэрт байдлын хорооноос санаачлан Увс аймгийн хаягдлын удирдлагын төв болох "Элемент" ХХК, Улаангом сумын удирдлагууд, аймгийн төвийн гэр хорооллын багаас аймгийн ИТХ-д сонгогдсон төлөөлөгчид, АЗДТГ, БОАЖГ-ын холбогдох мэргэжилтнүүдийг хамруулан Улаангом сумын хог хаягдлын менежмент, цаашид авах арга хэмжээний талаар уулзалт хэлэлцүүлгийг зохион байгууллаа.



Хэлэлцүүлэгт аймгийн ИТХ-ын Байгаль орчин, экологийн тэнцвэрт байдлын хорооны дарга Б.Анхбаяр, гишүүд С.Анхбаяр, Г.Цэрэндулам, Н.Тагаа, аймгийн ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч Д.Мягмарсүрэн, төлөөлөгч Я.Алтангэрэл, О.Ганцоож, Улаангом сумын ИТХ-ын дарга Н.Ганцогт, Засаг дарга Ц.Пүрэвжав, орлогч дарга Д.Бэгэжжав, АЗДТГ-ын ХОХБТХ-ийн байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Энхтуяа, БОАЖГ-ын мэргэжилтэн М.Төгөлдөр, "Элемент" ХХК-ны захирал П.Батбаатар, нягтлан бодогч Мөнхбуян, Байгаль орчны улсын байцаагч С.Буяндалай, байгаль хамгаалагч Д.Гэрэлцэцэг, А.Пүрэвсосор, Ш.Даваа нар оролцлоо.

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН АЖЛЫН ХЭСЭГ ӨВӨЛЖИЛТ ХҮНДЭРСЭН СУМДАД АЖИЛЛАЛАА

Аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/19 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгүүд 14-15-ны өдрүүдэд өвөлжилт хүндэрсэн зарим сумдад ажиллаж цаг үеийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, сумдын онцгой комисст заавар зөвлөгөө өгч, өвөлжилт хүндрэлтэй байгаа бүс нутгийн малчин өрхүүдээр орж нөхцөл байдалтай танилцан, тэдний санал хүсэлтийг сонсохын зэрэгцээ сумдын онцгой комиссын үйл ажиллагаа, төлөвлөгөөтэй танилцаж, гамигаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг шалах заавар зөвлөгөө өгөхийн зэрэгцээ сумдын төсөвт байгууллагуудаар үйл ажиллагаа, өвөлжилтийн бэлтгэл байдал хэрхэн хангаж ажиллаж байгаатай газар дээр нь танилцаж, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар заавар зөвлөгөө өгч ажиллав.





ЭСЭЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан аймгийн ИТХ, аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс санаачлан Улаангом сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Сурч боловсрох эрх” сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг 2016.12.20-ны өдрөөс 2017.01.05-ны хооронд зарласан ба уралдаанд нийт 19-н эсээ ирснээс Улаангом сумын



Чандмань-Эрдэм ахлах сургуулийн 12А ангийн сурагч Ц.Намуунаа 1-р байр, Маршал Ю.Цэдэнбалын нэрэмжит Улсын тэргүүний цогцолбор 1-р сургуулийн 11А ангийн сурагч Д.Мэндээ 2-р байр, Улаангом сумын Чандмань-Эрдэм ахлах сургуулийн 9А ангийн сурагч Ш.Ариунзаяа 3-р байр тус тус эзэллээ.

ХОВД СУМ

Сумын ЗДТГ, ИТХурлын хамтарсан хяналт шалгалтыг Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 2017 оны 01 сарын 6-7-ны хооронд Бөхмөрөн сумын удирдлуугуудтай хамтран Ачит нуурын орчим газруудад иргэдийн мэдээллийн дагуу хийлээ. Шалгалт хийх хугацаанд Баян өлгий аймгийн Ногооннуур, Өлгий сумын 50 гаруй иргэн зөвшөөрөлгүй загас агнаж байсан зөрчил илэрснийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд арга хэмжээ авлаа. Хяналт шалгалтанд ИТХ-ын төлөөлөгч, ИНХ-ын дарга, төрийн албан хаагч зэрэг 7 албан тушаалтан оролцлоо.



Мөн ИТХ-ын Тэргүүлэгчдээс



тэргүүлэгчид, төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилон баталсан удирдамжийн дагуу 2017 оны 1 дүгээр сарын 13-нд эрүүл мэндийн төв дээр ажиллаж ажилтай нь танилцан, судалгаа авч үүрэг чиглэл өглөө. ИТХ-аас сар бүрийг нэг байгууллагын нэрэмжит сар болгон ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд 2016 оны 01 дүгээр сарын 18-нд Эрүүл мэндийн төв нийтийг хамарсан ажлын хүрээнд байгууллагуудын дунд мөсний баярыг зохион байгууллаа. Энэ үйл ажиллагаанд 5 байгууллагын ажилтан хаагчид, иргэд 100 гаруй иргэн оролцож мөсний шагай эр, эм, мөсний сумо эр эм, тэжүүрийн уралдаан эр, эм, мөс мөргөлдүүлэх тэмцээнийг эр, эм төрөлүүдээр өрсөлдөж Ахлах сургууль 1-р байр, ЗДТГ 2-р, Эрүүл мэндийн төв 3-р байрыг тус эзэлж мөнгөн шагналаар шагнагдлаа.

САГИЛ СУМ:

Цаг үе өвөлжилт хүндэрч байгаа учраас аймгаас ОБГЗгаараас өвс тэжээлийн хангалтын арга хэмжээнд оролцож, малчдын хүндэрсэн зарим хот айлуудад өвс тэжээл хургах ажлыг зохион байгуулав.

Багуудын ИНХ-ын дарга, түүний Тэргүүлэгчид, Засаг дарга нарыг сонгох хурал 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр боллоо. ИТХ-ын дарга Х.Сайнбаяр, нарийн бичгийн дарга Г.Пүрэвсүрэн нар 4, 5-р багийн ИНХ-ын арга хэмжээнд оролцож, арга зүйгээр хангаж ажиллав. 1-р багийн ИНХ-ын дарга Н.Гантогтох, Засаг дарга Ц.Дэлгэр, 2-р багийн ИНХ-ын дарга Н.Соёл-Эрдэнэ, Засаг дарга Д.Түнэрэв, 3-р багийн ИНХ-ын дарга Л.Баян-Очир, Засаг дарга Б.Одонням, 4-р багийн ИНХ-ын дарга Л.Отгонбаяр, Засаг дарга Н.Цогбат, мөн багуудын ИНХ-ын Тэргүүлэгчид нийт 25 хүн шинээр сонгогдлоо.

МАЛЧИН СУМ

ИТХ-ын 3 дугаар хуралдаан хуралдуулж ИТХ-ын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл, Засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны



хөтөлбөр, сумын НЭЗ-ийг 2017 онд хөгжүүлэх зорилт, Төлөөлөгчийн Ёс зүйн дүрмийг тус тус баталлаа.

Мөн 2016 оны Багийн Засаг дарга, ИНХ-ын дарга тэргүүлэгч сонгох сонгуулиар багийн засаг дарга, ИНХ-ын даргаар сонгогдсон 8 хүнд 2 өдрийн 16 цагийн сургалт зохион байгууллаа. Энэ сургалтаар сумын ИТХ, ЗДТГ-ын бүх албад, албан байгууллагын зүгээс мэргэжилийн сургалт зохион байгуулж багийн ИНХ-ын дарга нарт тамга тэмдгийг нь хүлээлцүүлэх, Засаг дарга нарт “Батламж” гардуулах ажлыг зохион байгууллаа.



ЗАВХАН СУМ

Ардчилсан шинэ Үндсэн хуулийн 25 жилийн ойг тохиолдуулан 01/13 –нд сумын Оюутны зөвлөлтэй хамтран үдэшлэг, АХА / Үндсэн хууль, танин мэдэхүй, орон нутгийн мэдээлэл/ тэмцээн зохион байгуулсан. АХА тэмцээнд 58 хүн оролцсон. АХА тэмцээнд түрүүлсэн эхний 2 хүнийг сумын ИТХ шагнаж урамшуулсан.



Хаяг

Увс аймаг, Улаангом хот, 3-р баг
Ө.Бадрахын гудамж,
ЗДТГ-ын байр 210 тоот

Утас : 70453627

Факс : 70452214

И Мэйл:

info@khural.uv.gov.mn

Вэб сайт:

http://uvs.khural.mn/

Facebook:

Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал